



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 10 сарын 04 өдөр

Дугаар 91

Мандалговь

**Төрийн өмчөөс орон нутгийн өмчид
хөрөнгө бүртгэж авах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2018 оны 61 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

Нэг: Дундговь аймгийн МСҮТ-ийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, нийт 1,505,673,202 (нэг тэрбум таван зуун таван сая зургаан зуун далан гурван мянга хоёр зуун хоёр) төгрөгийн балансын үнэ, 705,990,761 (долоон зуун таван сая есөн зуун ерэн мянга долоон зуун жаран нэг) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг Сайнцагаан сумын ЗДТГазарт балансаас балансад шилжүүлсүгэй.

Хоёр: Хөрөнгө хүлээлцэх ажлыг хууль тогтоомж, журмын дагуу ажлын хэсэг томилон зохион байгуулахыг аймгийн Засаг дарга /О.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

Гурав: Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэж, тогтоолын биелэлтийг 2018 оны 10 сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэхийг Сайнцагаан сумын ЗДТГ-ын дарга / Б.Оюунчимэг/-т даалгасугай.

Дөрөв: Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар / С.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2018 оны 12 сарын 27-ний өдрийн
У дугаар тогтоолын хавсралт

Дундговь аймгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн балансаас
Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газрын балансад шилжүүлэх хөрөнгө

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Балансын үнэ	Хуримтлагдсан элгэлэл	Үллэгдэл үнэ
1	Хичээлийн байр	1977	1,145,402,707.0	472,721,752.7	672,680,954.27
2	Сургуулийн бохирын шугам	1977	3,500,000.0	3,500,000.0	0.0
3	Хичээлийн байрын халаалтын шугам	1999	5,652,000.0	2,153,142.8	3,498,857.2
4	Гуанзны барилга	1977	344,658,495.0	221,155,865.7	123,502,629.3
5	Гуанзны бохирын шугам	1977	1,750,000.0	1,750,000.0	0.0
6	Гуанзны халаалтын шугам	1998	4,710,000.0	4,710,000.0	0.0
НИЙТ ДҮН			1,505,673,202.0	705,990,761.2	799,682,440.8
			(нэг тэрбум таван зуун таван сая зургаан зуун далан гурван мянга хоёр зуун хоёр төгрөг)	(долоон зуун таван сая есөн зуун ерэн мянга долоон зуун жаран нэгэн төгрөг хоёр мөнгө)	(долоон зуун ерэн есөн сая зургаан зуун наян хоёр мянга дөрвөн зуун дөчин төгрөг найман мөнгө)

